

ТӨМӨР ЗАМЫН ТЕХНИКИЙН БАРИМТ БИЧИГ, НОРМ, СТАНДАРТЫН САНГИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ БҮРДҮҮЛЭХ, ЗАРЦУУЛАХ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Төмөр замын техникийн баримт бичиг, норм, стандартын сан /цаашид “Сан” гэх/-ийн эх үүсвэрийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2.Сангийн эх үүсвэрийг бүрдүүлэх, уг сангаас төмөр замын техникийн баримт бичиг, норм, стандарт /цаашид “техникийн баримт бичиг, норм, стандарт” гэх/-ын судалгаа хийх, боловсруулах, батлуулах, хэвлэн олшруулах, сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулан санхүүжүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах, хяналт тавих үүргийг төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага “цаашид “төрийн захиргааны байгууллага” гэх/ хариуцна.

1.3.Сангийн хөрөнгөөр техникийн баримт бичиг, норм, стандартыг боловсруулахад салбарын эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, төмөр замын барилга, засвар, техник эдийн засгийн үндэслэл, зураг төслийн ажил, зөвлөх үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээд, иргэдийн оролцоог хангах зарчмыг баримтална.

1.4.Сангийн орлогыг Төрийн сан дахь харилцах дансанд төвлөрүүлэх бөгөөд уг дансны 1 болон 2 дугаар гарын үсгийг төрийн захиргааны байгууллагын дарга болон ерөнхий нягтлан бодогч тус тус зурна.

Хоёр. Сангийн удирдлага, зохион байгуулалт

2.1.Техникийн баримт бичиг, норм, стандартыг боловсруулах, хянуулах, батлуулах, хэвлэн олшруулах, сурталчлах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, сангийн үйл ажиллагааг удирдах үүрэг бүхий үүрэг бүхий Сангийн удирдах зөвлөл /цаашид “Удирдах зөвлөл” гэх/, сангийн үйл ажиллагаа, хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтыг хянах Хяналтын зөвлөл /цаашид “Хяналтын зөвлөл” гэх/ тус тус ажиллана.

2.2.Удирдах зөвлөл нь 9, хяналтын зөвлөл нь 5-аас доошгүй гишүүнтэй байна. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг төмөр замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

2.3.Зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, төмөр замын төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулна. Удирдах болон Хяналтын зөвлөлийн гишүүн нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5.3 дахь заалтын шаардлагыг хангасан байна.

2.4.Удирдах зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.4.1.сангийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг хянан хэлэлцэж батлах;

2.4.2. тухайн жилд боловсруулах техникийн баримт бичиг, норм, стандартыг хэвлэх, олшруулах, сурталчилах эдгээртэй холбоотой гадаад, дотоодын сургалт, хурал, эрдэм шинжилгээ, судалгааны ажил, олон улсын стандарт, норм, баримт бичиг, техник, тоног төхөөрөмж худалдан авахад шаардагдах хөрөнгийн хэмжээг батлах;

2.4.3. техникийн баримт бичиг, норм, стандартын боловсруулалтын ажлын явц, тайланг хэлэлцэж, холбогдох арга хэмжээг авах;

2.4.4. сангийн үйл ажиллагаа, хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, хяналтын тайланг хэлэлцэн дүгнэх.

2.5. Удирдах зөвлөл нь сангийн санхүүгийн жилийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэн дүгнэж, дараа жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан хэлэлцэж, батална.

2.6. Удирдах зөвлөлийн хурал бүх гишүүдийн гуравны хоёроос доошгүй ирцтэй хуралдаж, олонхийн саналаар шийдвэр гаргана.

2.7. Удирдах зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлэсэн асуудлаар хурлын тэмдэглэл хөтөлж, түүнийг Зөвлөлийн дарга баталгаажуулна.

2.8. Удирдах зөвлөлийн дарга нь төрийн захиргааны байгууллагын дарга, дэд дарга нь төрийн захиргааны байгууллагын тухайн асуудал хариуцсан нэгжийн дарга байна. Зөвлөлийн даргын эзгүйд дэд дарга ажил үүргийг орлон гүйцэтгэнэ.

2.9. Удирдах зөвлөлийн дарга нь дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.9.1. Удирдах болон Хяналтын зөвлөлийн гишүүдийг томилуулах, чөлөөлөх, гишүүдэд олгох урамшууллыг тогтоох талаар санал боловсруулан төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулж, шийдвэрлүүлэх;

2.9.2. техникийн баримт бичиг, норм, стандартыг боловсруулах дарааллыг тогтооход санал оруулах, сангийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах;

2.9.3. сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зориулалт, зарцуулалтын талаар илэрсэн зөрчил, дутагдлыг цаг тухайд нь арилгуулах.

2.10. Хяналтын зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.10.1. сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих;

2.10.2. сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавих;

2.11. Төрийн захиргааны байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.11.1. Төмөр замын тээврийн тухай хуулийн 13 дугаар зүйл, 10 дугаар зүйлийн 10.2.1, 10.2.2, 10.2.8, 10.2.10, 10.2.15 дахь заалтууд болон энэ журамд заасны дагуу Удирдах зөвлөлийн баталсан жилийн төлөвлөгөө, шийдвэрийг үндэслэн сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих;

2.11.2. Сангийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг гүйцэтгэх зөвлөх, энэхүү журмын 2.11.4-т заасан хараат бус хүн, хуулийн этгээдийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх;

2.11.3.техникийн баримт бичиг, норм, стандартыг боловсронгуй болгох, олон улсын түвшинд хүргэх чиглэлээр судалгаа, шинжилгээ хийж, үндсэн чиглэл, хөтөлбөр боловсруулах, гадаад орны туршлагыг судлан шаардлагатай стандарт, норм, техникийн баримт бичгийг худалдан авах;

2.11.4.техникийн баримт бичиг, норм, стандартын төсөлд мэргэжлийн түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн хүн, хуулийн этгээдээр шүүмж, редакц хийлгэх, санал, дүгнэлт гаргуулах;

2.11.5.Удирдах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын төслийг бэлтгэж, хэлэлцүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

2.11.6.техникийн баримт бичиг, норм, стандартыг боловсруулах, хэвлэн олшруулах, сурталчлах, хэрэгжилтийг хангах, цахим сан байгуулж, тогтмол баяжуулах ажлыг зохион байгуулах;

2.11.7.батлагдсан төлөвлөгөөний дагуу техникийн баримт бичиг, норм, стандартыг боловсруулахад шаардлагатай ном хэвлэл, аргачлал, заавар, програм хангамж, тоног төхөөрөмж, техникийн баримт бичиг худалдан авах.

2.11.8.эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр туршлага судлах, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах, төмөр замын тээврийн салбарт шинжлэх ухаан технологи, инновацыг нэвтрүүлэх төлөвлөгөө, төсөл боловсруулж хэрэгжүүлэх;

2.11.9.техникийн баримт бичиг, норм, стандартын эх материал болон төсөлд шүүмж, редакц хийлгэсэн санал, дүгнэлт, худалдан авах үйл ажиллагаа зохион байгуулсан холбогдох материалыг архивын нэгж болгон хадгалах;

2.11.10.төмөр замын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, шинэ дэвшилтэт техник технологи, холбогдох баримт бичиг, норм, стандартыг судлах зорилготой гадаад, дотоодын хурал, зөвлөгөөн, сургалт, семинарт мэргэжлийн байгууллага, ажилтнуудыг хамруулах асуудлыг сангийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулан хэрэгжүүлэх.

Гурав. Сангийн орлогын эх үүсвэр

3.1.Сангийн хөрөнгө нь Төмөр замын тээврийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасан эх үүсвэрээс бүрдэнэ.

3.2.Хүн, хуулийн этгээд нь тухайн жилд гүйцэтгэх төмөр замын суурь бүтцийг барих, өргөтгөх, шинэчлэх, зураг төсөл боловсруулах ажлын төсөвт өртгөөс 0.4 хувиар тооцож, гүйцэтгэлийн санхүүжилт олгогдох тухай бүрт сангийн дансанд төвлөрүүлнэ.

3.3.Төмөр замын техникийн баримт бичиг, норм, стандарт борлуулсны орлого болон төмөр замын техникийн баримт бичиг, норм, стандартыг боловсронгуй болгох зорилгоор өгсөн хандивыг тухай бүр дансанд төвлөрүүлнэ.

3.4.Санд хөрөнгө төвлөрүүлээгүй буюу дутуу төвлөрүүлсэн хүн, хуулийн этгээдийн төлбөрийг санд нөхөн төвлөрүүлэх ажлыг төрийн захиргааны байгууллага зохион байгуулна.

3.5.Гадаад улс, олон улсын байгууллага, дотоодын болон гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, иргэдээс аливаа нөхцөл, болзол тавьсан хөрөнгийн эх үүсвэрийг санд оруулахгүй.

Дөрөв. Сангийн хөрөнгийн зарцуулалт

4.1.Сангийн хөрөнгийг дараах үйл ажиллагаанд зарцуулна:

4.1.1.техникийн баримт бичиг, норм, стандартыг боловсруулах, судалгаа, шинжилгээ, шүүлт, үзлэг хийх, редакц, шүүмж хийлгэх, эмхэтгэн хэвлүүлэх, сурталчлах зардал;

4.1.2.техникийн баримт бичиг, норм, стандартыг боловсруулахад шаардлагатай ном хэвлэл, аргачлал, заавар, олон улс, бүс нутаг, гадаад орны техникийн баримт бичиг, норм, стандарт худалдан авах зардал;

4.1.3.олон улсын мэргэжлийн байгууллагын гишүүнчлэл, хамтын ажиллагааны зардал;

4.1.4.техникийн баримт бичиг, норм, стандартыг боловсронгуй болгохтой холбоотой гадаад, дотоодын хурал, зөвлөгөөн, сургалт, семинарт холбогдох ажилтнуудыг оролцуулах, тэдгээрийг зохион байгуулах, туршлага судлах, судалгаа шинжилгээ хийх, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллахад шаардагдах зардал;

4.1.5.техникийн баримт бичиг, норм, стандартын судалгааны ажлын тайланг Төмөр замын салбарын шинжлэх ухаан технологийн дэд зөвлөл, Стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцүүлэхэд шаардагдах зардал;

4.1.6.Монгол Улсын төмөр замын суурь бүтэц, салбар замын бүртгэл, мэдээллийн нэгдсэн цахим санг үүсгэх, баяжуулах, шинэчлэх, шаардлагатай програм хангамж, тоног төхөөрөмж худалдан авах, бичиг хэргийн болон шуудан харилцааны зардал.

4.1.7.Сангийн удирдах болон Хяналтын зөвлөлийн гишүүдийн урамшууллын зардал;

4.2.Сангийн хөрөнгийг энэ журамд зааснаас бусад зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно.

Тав. Сангийн үйл ажиллагааг тайлагнах

5.1.Төрийн захиргааны байгууллага нь сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтын эхний хагас жилийн тайланг тухайн оны 07 дугаар сарын 15-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайланг дараа оны хоёрдугаар сарын 15-ны өдрийн дотор Удирдах зөвлөлд тайлагнана.

5.2.Сангийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг төрийн захиргааны байгууллагын цахим хуудсанд байршуулж, хэрэгжилтийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлнэ.

5.3.Хяналтын зөвлөл нь сангийн үйл ажиллагаа, хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад жилд нэгээс доошгүй удаа хяналт, шинжилгээ хийж, тайланг Удирдах зөвлөлд танилцуулна.

Зургаа. Хариуцлага

6.1 Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Зөрчлийн тухай хууль эсхүл Эрүүгийн хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.